

ХИЛЧДИЙН АЛБА, АМЬДРАЛ ХҮНДЭТ ЧЕКИСТ, БЭЛТГЭЛ ДЭД ХУРАНДАА ШАГДАРЫН БӨНЖИН

Ж.Өвгөнбүргэд

Доктор, хурандаа

Ш.Бөнжин Говь-Алтай аймгийн дунд сургуульд багшилж байгаад 1945 оны 6 дугаар сард цэргийн албанд татагдан ДЯЯ-ны харьяа Цэргийн нэгдсэн төв сургууль хуваарилагдан нэг жил сураад офицер болж, хэл бичгийн багш хийжээ. Уг сургууль нь 1951 оны 8 дугаар сард татан буугдахад газрын штабт томилогдон ажиллажээ.



Тусгай хороонд 1953 онд, 1956 оны 6 дугаар сар хүртэл Өмнөговь аймгийн Ноён сум дахь Овоотын пунктэд, 1956 оны 6 дугаар сараас Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот дахь байцаан өнгөрүүлэхэд шалгагчаар ажиллажээ.

Тэрээр 1960 онд ЗХУ-ын Солнечногорскт “Буудлага

тактикийн дээд курст суралцаж ирээд, 1961-1968 онд тусгай хороонд байлдааны бэлтгэлийн офицероор, 1968 оны 5 дугаар сард газрын штабт байлдааны бэлтгэлийн офицероор, 1969 оны 7 дугаар сард Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум хилийн 0146 дугаар анги шинээр байгуулахад цэргийн тэтгэвэрт гарчээ.

Бөнжин дэд хурандаа 0146 дугаар ангийн штабын даргаар 1969-1971 онд ажиллаад хошууч Л. Тэрбишид ажлаа өгч дараа нь газрын штабт дайчилгааны офицер, операторын жижүүр, Өмнөговийн отрядын штабын даргаар ажиллаж байгаад 1978 онд тэтгэвэрт гарсан гэж намтарт нь бичсэн байна. /З.Гүнбаатар/

Тэтгэвэрт гарснаас хойш хилийн застав, отрядад 15-70 хоногийн томилолтоор очиж залуу офицеруудад өөрийн ажлын арга, туршлагаас зааж хамтран ажиллаж байжээ.

Хилийн Цэргийн ахмадын үйлдвэрт 1990-1998 он хүртэл хугацаанд ажиллаж, цэрэг эмээл угсарч 0164 дугаар ангид өгч байсан байна.

Монгол-Хятад улсын хилийн шугамыг 1982 онд тодотгох, бүх баганыг үзэж засварлах, туслах чанарын 24 баганыг суурилуулах ажлын хэсгийн 5 дугаар салбар комиссын даргаар ажиллаж байжээ.

Дэд хурандаа Бөнжин гуай 1973 онд Сулинхээрийн хилийн 0168-р анги дахин байгуулагдахад Штабын дарга байсан. Намайг Хилийн цэргийн дээд сургууль төгсөөд очиход анх тосож авсан хүн

дээ. Монгол бичгээр гайхамшигтай
түргэн бичнэ. /Д.Шаравшагдар/
**ХИЛИЙН СУРГУУЛИЙН
БАХАРХАН ДУУРСАХ
АЛДАРТАН**

Ахмад хилчин Шагдарын
Бөнжинтэй 2017 онд хийсэн
ярилцлага.

Монгол Улсад хил хамгаалах
байгууллага үүсэн байгуулагдсаны
83 жилийн түүхт ойн босгох дээр
ахмад дайчин ахмад хилчин тантай
уулзаж байгаадаа таатай байна. Та
хил хамгаалах албанд ажиллаж
байсан талаараа бидэнд ярьж
сонирхуулна уу ?

Та бүхэнд болон хил хамгаалах
албанд ажиллаж байгаа нийт хамт
олондоо баярын мэнд хүргэе. Намайг
Шагдарын Бөнжин гэдэг. Би 1924 онд
Завхан аймгийн Чандмань –Өлзийт
\одоогийн Яруу сум/ -нд Баврайн
Таван толгой гэдэг газар төрсөн.
Тэндээсээ Түдэвтэй суманд шилжин
аав ээж ах эгч нарын хамт мал
маллаж байгаад Завхан аймгийн
Галуутайн бага сургуульд сурч
төгсөөд Буриад улсын нийслэл
Улаан-Үдэд багшийн сургууль
Монгол рабфакт 1938 онд очоод сурч
байтал 1941 онд эх орны дайн эхэлж
сургууль татан буугдсан учир
Монголдоо ирж Багшийн сургуульд
дөрвөн жил сураад тэр үеийн Говь-
Алтай аймгийн дунд сургуульд хэл
бичгийн багш хийж байгаад 1945 оны
05 дугаар сард цэрэгт татагдан ДЯЯ-
ны Цэргийн нэгдсэн төв сургуульд
хуваарилагдан нэг жил сураад 1947
оны 03-р сард офицер болж хэл
бичгийн багшаар Төв сургууль 1951
онд татан буугдтал багшилсан.

- Таныг багшилж байсан Төв
сургууль/ Одоогийн ХСИС-ийн
харьяа Хилийн Сургууль/ ямар

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг
байсан бэ?

Төв сургууль сурагчдыг гурван
жилийн хугацаатайгаар захиран
командлах, улс төр, гүйцэтгэх
албаны чиглэлээр сурган ДЯЯ,
Хилийн ба Дотоодын цэрэг, Цагдан
сэргийлэхэд ажиллах боловсон
хүчнийг бэлтгэн хангадаг байлаа.
1951-1953 онд хилийн бүх анги
салбар, Удирдах газар татан буугдаж,
хил манах зорилгоор 16 пункт
ажиллах болж, сургууль татан
буугдсан тул намайг одоогийн
Өмнөговь аймгийн Ноён сум дах
Овоотын пунктэд томилон
ажиллуулах шийдвэр гарч тэндээ 2
жил ажиллаад, дараа нь Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар хотод байцаан
өнгөрүүлэхэд шалгагч хийж байгаад
тэр үеийн ЗХУ-д буудлага тактикийн
дээд курст сурч ирээд Тусгай
хороонд 1961-1968 он хүртэл
байлдааны бэлтгэл офицероор
ажилласан. 1968 онд Сүхбаатар
аймгийн Эрдэнэцагааны отряд, 1976
онд Сулинхээрийн отряд, шинээр
байгуулагдахад отрядын штабын
даргаар ажилласан. Хилийн отряд
заставд 15-30 хоногийн томилолтоор
очиж залуу офицеруудад хилийн
албанд дадлагашуулах, тэсвэр
хатуужил сургах, хил хамгаалах арга
тактикийн талаар өөрийн ажлын арга
туршлагаас ярьж хамтран ажиллаж
байлаа.

-Тэр үеийн хилийн цагийн
байдал ямар байсан бэ?

Ер нь 1960-аад оноос хил
хязгаарын байдал болон дэлхийн
дайн байлдааны цагийн байдал
намжсан, урд хөрш БНХАУ-тай энх
тайван найрамдалт харилцаа тогтож,
төр засгийн зүгээс хил хязгаарыг
сахин хамгаалах үүргийг ДЯЯ-нд
шилжүүлэн хилийн цэрэг

пунктүүдээр хил манах үүргийг хүлээж тэр үед цэргийн сургууль төгсөн офицерууд, давтан болон түргэвчилсэн сургалтад хамрагдсан хүмүүс, цэргийн бага мэргэжилтнүүд холбоочин радист, хими инженер, мал эмнэлгийн чиглэлээр сургагдсан хилчид байсан юм. Тэр үед хил дээр дайсагнасан болон өдөөн хатгасан зэрэг үйлдлүүд гардаггүй цагийн байдал намжсан байсан боловч хил давж мал орж ирэх, салхи шуурга ихтэй үед малчид болон төөрсөн хүмүүс гадаадаас болон дотоодоос хилийн зөрчил гаргаж болзошгүй байсан ба хилийн албаны сурталт эзэмшсэн үүрэг хүлээсэн дайчид хамгаалдаг байсан учраас хилийн зөрчлийг таслан зогсоож чаддаг байлаа. Би Монгол улсынхаа хил хязгаарыг сахин хамгаалах үйлсэд сэтгэл зүрх эр зориг гарган хилийн албанд ажиллаж байсан маань миний насан туршийн бахархал байдаг. Би 1978 оны 03-р сард эрүүл мэндийн байдлаас шалтгаалж цэргийн тэтгэвэрт гарч, тэр үед ажиллаж байсан хилийн цэргийн ахмадын харьяа эмээлийн үйлдвэрт 6 жил ажиллаж цэрэг эмээл угсарч сард 50 эмээл бэлтгэн бэлэн болгож, хилийн 0164 дүгээр ангийн хангалтын ангид өгдөг байсан.

Мөн Монгол-Хятадын засгийн газрын хэлэлцээрийн дагуу хилийг 5 жилд нэг удаа хамтран шалгах тавдугаар салбар комиссын даргаар Сулинхээрийн отрядын участикт хилийн шугамыг тодотгох ажлаар хилийн бүх баганыг нэг бүрчлэн үзэж засварлах, багана бүрийн зургийг авах, туслах чанарын 24 баганыг зохих газарт нь босгох ажлыг 2 хэсэгтэйгээр ажиллаж бүх ажлаа 1982 оны 01-р сараас 11-р сар хүртэл хугацаанд дуусгаж материалаа улсын

төв комисст өгсөн. Намайг үүргээ сайн биелүүлсэн гэж Монгол улсын Ерөнхий сайд Ж.Батмөнх Засгийн газрын Хүндэт жуух бичгээр шагнаж байсан.

Миний гавьяа зүтгэлийг үнэлж төр засгаас үнэлж Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Алтан гадас одон, Тусгаар тогтнолын одон, Ардын хувьсгалын ойн медалиуд, ХХЕГ-ын анги салбаруудын дурсгалын тэмдэг медалиудаар шагнагдсан.

- Танд баярлалаа. Анх удаагаа эрхлэн гаргах гэж байгаа Сүлдэт Багана сэтгүүлд анхдагч болж чин сэтгэлийн ярилцлага өгсөн танд урт удаан насалж, эрүүл энх байхыг хүсэн ерөөе.

Та бүхэнд ч гэсэн амжилт хүсье. Сүлдэт баганаараа овоглосон энэ байгууллага маань улам өргөжин тэлж хил хамгаалах ариун үйлсийг ард түмэнд сурталчлан, хил хамгаалах албанд зүтгэж байгаа болон хил хамгаалах албанд ажиллаж байсан баатарлаг хүмүүс, суутнуудыг алдаршуулах, ахмад дайчид тэдний ар гэрийнхнийг холбож аж байдлыг нь судалж хамтран ажиллах сайхан боломж бололцоог нээж өгч буй танай байгууллагын удирдлага, хамт олонд талархаж байгаа илэрхийлье.

"Сүлдэт багана-Хилчдийн холбоо"-ны Удирдах зөвлөл.